

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН “ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА”-НЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2026 оны 01 дүгээр сарын 12

Улаанбаатар хот

Тайлант хугацаанд нийт 9 олон нийтийн арга хэмжээ хэрэгжүүлж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Нэг. Спортын тэмцээн уралдаан

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/06 дугаар тушаалаар “Соёл, спортын хамтлаг байгуулж, тушаал хүчингүй болгох тухай”-ийн ажлын хэсэг 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан, хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, 01 дүгээр сарын 20-ний өдөр газрын даргаар батлуулан ажиллаж байна.

2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар нийт 4 удаагийн тэмцээн, уралдаан зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 170 албан хаагч хамрагдав.

Төлөвлөгөөний хүрээнд газрын хэмжээнд 4 төрлийн тэмцээнийг зохион байгуулав.

1. Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эв нэгдлийг сайжруулах, багаар хамтарч ажиллах чадварт сургах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, “Соёл, спорт хамтлаг”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд “Гар бөмбөг”, “Дартс”-ын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах удирдамж, хөтөлбөр гаргаж, газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлуулав.

Тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн спорт зааланд “Соёл, спорт хамтлаг”-ийн ажлын хэсэг зохион байгуулав. Нийт 5 багийн 85 тамирчин оролцож, мэргэжлийн шүүгчид шүүн явуулав.

Тэмцээнийг нээж Захиргааны хэлтсийн дарга Х.Батхүү үг хэлж, баг тамирчдад амжилт хүсэв.



“Гар бөмбөг”-ийн эрэгтэй, эмэгтэй төрөлд 5 багийн тамирчид амжилттай оролцсоноос:

Эрэгтэй баг 1-р байр Амиго баг
2-р байр Хар ирвэс баг
3-р байр Goods баг



Эмэгтэй баг 1-р байр The white devils баг

2-р байр Амиго баг
3-р байр Groods баг тус тус шалгарч медаль, үнэмлэх, мөнгөн шагналаар шагнагдав.



Дартсын эмэгтэй төрөлд 1-р байр Амиго баг
2-р байр Groods баг
3-р байр Хар ирвэс баг

Эрэгтэй төрөлд 1-р байр The white devils баг
2-р байр Металл баг

3-р байр Groods баг тус тус шалгарч медаль, үнэмлэх, мөнгөн шагналаар шагнагдав.



2. "Сагсан бөмбөг", "Ширээний теннис"-ний аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах удирдамж, хөтөлбөр боловсруулан, газрын даргаар 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр батлуулан, "Соёл, спорт хамтлаг"-ийн ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Тайгер спорт зааланд зохион байгуулж, нийт 85 албан хаагч оролцов.

Тэмцээнийг нээж газрын газрын дарга Б.Мөнхбат үг хэлж, баг тамирчдад амжилт хүсэв.



Эрэгтэй, эмэгтэй төрөлд 5 багийн тамирчид амжилттай оролцсоноос:

Эрэгтэй баг 1-р байр Groods баг
2-р байр Металл баг
3-р байр Хар ирвэс баг



Эмэгтэй баг 1-р байр The white devils баг
2-р байр Groods баг
3-р байр Амиго багууд тус тус шалгарч, медаль, үнэмлэх,

мөнгөн шагналаар шагнагдав.



Дартсын эмэгтэй төрөлд 1-р байр Groods баг
2-р байр The white devils баг
3-р байр Хар ирвэс баг

эрэгтэй төрөлд 1-р байр Хар ирвэс баг
2-р байр The white devils баг

3-р байр Groods баг тус тус шалгарч медаль, үнэмлэх,

мөнгөн шагналаар шагнагдав.



Дөрвөн төрөлт тэмцээний нийлбэр дүнгээр багуудыг байр эзлүүлэв. Үүнд:

1 дүгээр байр - Goods баг

2 дугаар байр - Амиго баг

3 дугаар байр - The white devils баг тус тус шалгарч, шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.



Бусад цаг үеийн олон нийтийг хамарсан спортын тэмцээн уралдаанд (Цасны баяр, Барилгын зураг төсөл зохиогчдын холбооны тэмцээн, Улаанбаатар марафон-2025) тухай бүр зохион байгуулалтыг хангаж, оролцов.

1. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийслэлийн “Өвлийн спортын наадам”-ын нээлтийг зохион байгуулах тухай удирдамжийн хүрээнд албан хаагчдыг өвлийн биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулахаар төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр газрын даргаар батлуулав.

2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр “Скай резорт” цанын баазад зохион байгуулагдаж, нийт 67 албан хаагч оролцов.



Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хоёр төрлийн (явган алхалт, бүжиг) тэмцээн зохион байгуулж, албан хаагчид амжилттай оролцов.

Бүжгийн тэмцээнд Ц.Тамираа, П.Хорол-Эрдэнэ, Д.Солонго, Э.Энхтөгөлдөр нар амжилттай оролцов.



Явган алхалтын тэмцээнд эрэгтэй 6, эмэгтэй 6 албан хаагч оролцож, тэргүүн байр эзэлж, цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.



2. Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооноос 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр ирүүлсэн 01/28 дугаар албан бичгийн хүрээнд барилга хот төлөвлөлтийн зураг төсөл зохиогч гишүүн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын тэмцээнд газрын баг тамирчид амжилттай оролцов.

Тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 26-27, 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 3 төрлийн тэмцээнд 17 албан хаагч төрөл тус бүрд амжилттай оролцов.Үүнд:

1. “Дартс”-ын тэмцээний эрэгтэй төрөлд Э.Батцэнгэл, Э.Элдэв-Очир, Б.Туяажаргал
2. “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнд эрэгтэй-7, эмэгтэй-7 албан хаагч тус тус оролцож, эмэгтэй баг тамирчид Хүрэл медаль хүртэв.



Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Хамтран ажиллах тухай” 02/82 дугаар албан бичгийн хүрээнд удирдамжийн дагуу зохион байгуулалтыг хангаж ажиллав.

“Улаанбаатар марафон 2025” гүйлтийн талаарх мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан, албан хаагчдад мэдээлэл хүргэв. 5 км-ийн зайд 21, 21 км-ийн зайд гүйх 5 албан хаагчийн мэдээллийг <http://ubmarathon.hiray.mn/> хаягаар онлайнаар бүртгэж, төлбөрийг hīray апплейкешнаар хийж баталгаажуулав. Энгэрийн дугаарыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас авч, албан хаагчдад олгож, гүйлтийн бэлтгэл ажлыг хангав.



“Улаанбаатар марафон 2025” олон улсын гүйлт 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдаж, нийт 20 албан хаагч амжилттай оролцов.



Гүйлтэд оролцсон талаарх мэдээллийг газрын цахим хуудсаар нийтлэн ажиллав.



Хоёр. Олон нийтийн арга хэмжээ:

Нийслэлийн харьяа байгууллагуудаас зохион байгуулагдсан 3 удаагийн олон нийтийн арга хэмжээнд давхардсан тоогоор 54 албан хаагч оролцов.

1.Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/354 дүгээр захирамжийн дагуу “ХОГ ХАЯГДАЛ, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийтийн их цэвэрлэгээнд “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын хамт олон хамрагдав. 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 11:00-12:30 цагийн хооронд Соёлын төв өргөөний 4 талын зам, талбай (Амарын гудамж, Их сургуулийн гудамж) явган хүний замыг цэвэрлэн ил задгай хог хаягдлыг нийт 19 албан хаагч цэвэрлэв.



2. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны "Эзэнгүй муур, нохой барих нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай А/50 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын нийт 20 албан хаагч 2025 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд Баянзүрх дүүргийн 2,21,27,29, 10,12,13, 37,14 ,42 дугаар хороодод ажилласан.

Албан хаагчид хариуцсан хороодын Ажлын албатай хамтран нийт **28 муур, 79 нохойг** барьж мэргэжлийн байгууллагад нь хүлээлгэн өгч, хамтран ажилласан. **Ажилласан өдрийн мэдээлэл:**

№	Ажилласан албан хаагчид	Хариуцсан хороод	Нохой муурны тоо
2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр ажилласан байдал			
1	Б.Төрмөнх	2	2 муур, 15 нохой
2	М.Энхтөр		
3	Д.Гантулга		
4	Ч.Идэрхангай	21	12 нохой
5	Т.Нямтогтох		
6	М.Батмягмар		
7	Г.Лхагвадорж	27	2 муур, 22 нохой
8	Т.Билгүүн		
9	Э.Батцэнгэл	29	2 муур, 7 нохой
10	Б.Билэгжаргал		
11	Нийт	4	6 муур, 56 нохой

№	Ажилласан албан хаагчид	Хариуцсан хороод	Нохой муурны тоо
2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр ажилласан байдал			
1	Э.Батжаргал	10	3 муур 6 нохой
2	Ц.Тамираа		
3	Ж.Мөнхнаран	12	8 муур 3 нохой
4	А.Дамбадагва		
5	З.Даваадорж	13	1 муур 8 нохой

6	Б.Бат-Оргил	14	5 муур 1 нохой
7	Э.Элдэв-Очир	37	5 нохой
8	П.Хорол-Эрдэнэ		
9	Л.Гансүх	42	5 муур
10	Г.Сэр-Од		
11	Нийт	6	22 муур 23 нохой



3.Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар батлагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын албан хаагчид Налайх дүүргийн “Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн”-д 2025 оны 05 дугаар сарын 04-ний өдөр нийт 160 хайлаас модыг тарьж, усалгаа хийж нийт 13 албан хаагч ажиллалаа.



4.Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/822 дугаартай албан бичиг, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 10 дугаар сарын 02-ны 03/1999 өдрийн албан бичгийн хүрээнд “Тэрбум

мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын албан хаагчид Налайх дүүргийн “Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн”-д 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр нийт 15 буйлс модыг тарьж, усалгаа хийж нийт 7 албан хаагч ажиллав.



ЗАХИРГААНЫ ХЭЛТЭС